



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/02

Хажуу шинэ-Ус

Цалин батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, "Төсвийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, "Төрийн албаны тухай" хуулийн 57 дугаар зүйлийн 57.17, Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 5, Засгийн газрын 2022 оны Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" 107 дугаар тогтоолын 2 дах заалт, Засгийн газрын 2022 оны "Төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 488 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 12 дугаар хуралдааны "Аймгийн 2023 оны төсөв батлах тухай" 04 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны А/18 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагч нарын ажилласан хугацаа, Засгийн газрын 2022 оны Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" 107 дугаар тогтоолын 2, Засгийн газрын 2022 оны "Төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 488 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 12 дугаар хуралдааны" Аймгийн 2023 оны төсөв батлах тухай" 04 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны А/18 тоот захирамжийн дагуу 2023 оны 01 дүгээр сарын 01-с эхлэн цалинг шинэчлэн тогтоосугай.

2.Төрийн албан хаагч нарын албан тушаал, нэрс, цалингийн зэрэглэл шатлал хэмжээг хавсралтаар баталсугай.

3.Үндсэн цалинг хавсралтаар батлагдсан хэмжээгээр тооцож холбогдох шийдвэрүүдийг үндэслэн нэмэгдлүүдийг журмын дагуу олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (У.Сүнжидмаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Н.ӨЛЗИЙТОГТОХ

